

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



/2019 оны ажиллах хүчний судалгааны дүнгээр/

ОРШИЛ

Ажиллах хүчний судалгаагаар хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодит тоон мэдээллийг улсын хэмжээнд болон бүс нутаг, аймаг, нийслэл дүүргийн түвшинд тооцож гаргадаг.

ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газрын Ажиллах хүчний судалгааны алба хариуцан судалгааны асуулга боловсруулах болон мэдээллийг боловсруулах, нэгдсэн үр дүнг гаргах, тайлагнах ажлуудыг хийж гүйцэтгэдэг.

Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлыг нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн ажиллах хүчний судалгаа хариуцсан багийн ажилтнууд хийж гүйцэтгэдэг ба судлаач нь тухайн сард сонгогдсон өрхөд очиж 15, түүнээс дээш насны гишүүн бүртэй нэг бүрчлэн уулзаж, ярилцлага хийх замаар мэдээллээ цуглуулдаг. Судалгааны мэдээллийг судлаач таблетаар цуглуулсан, зааврын дагуу шалгаж, кодлон интернет орчинд ҮСХ-ны төв серверт байршуулдаг. Судлаачийн төв серверт байршуулсан мэдээллийг тухайн аймаг, нийслэлийн судлагааны багийн ахлагч серверт хандан шалган, ахлагчийн таблетаас эцэслэн дамжуулах замаар ҮСХ-нд мэдээлэл нэгтгэгддэг.

Судалгаа нь өрхөд суурилан явагддаг тул цэргийн хуаран, дотуур байр засан хүмүүжүүлэх газар, сүм хийд болон нийтийн байранд түр амьдрагчид, байнгын орон гэргүй хүн амыг хамруулаагүй болно. Мөн тухайн өрхөд 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа /хугацаат цэргийн албан хаагч, оюутан, сурагчид, гадаадад ажиллаж байгаа болон цагдан хоригдож байгаа / иргэдийг оруулаагүй болно.

Ажиллах хүчний судалгааны үр дүнг дүүргийн хэмжээнд жил бүр оны эцсийн байдлаар дүүргийн түвшний мэдээллээр нэг удаа бэлтгэн хэвлэж гарган тархааж байна.

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөдөлмөрийн зах зээл маш хурдацтай өөрчлөгдөж буй өнөөгийн цаг үетэй хөл нийлүүлэн, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг бодитоор харахын тулд Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 19-р бага хурлын тогтоолыг өөрийн орны онцлогт тусган, ойлголт, тодорхойлолт, аргачлалаа шинэчлэн боловсронгуй болгох шаардлагын дагуу 2019 оны 1 дүгээр сараас эхлэн Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг мөрдөж байна. Иймд хөдөлмөрийн зах зээлийн дээрх үзүүлэлтүүдийг өмнөх онтой харьцуулах боломжгүй юм.

Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 19-р бага хурлын "Ажил, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний дутуу ашиглалт"-ын талаарх тогтоолын дагуу хөдөлмөрийн статистикт гарсан томоохон өөрчлөлтийг дурдвал:

- **Хөдөлмөрийн статистикийг** НҮБ-ын үндэсний тооцооны системтэй зарчмын хувьд уялдуулах боломжтой болсон;
- Цалин авч байгаа эсэхээс үл хамааран шинээр **ажил, түүний хэлбэрүүдийг** тооцох үзүүлэлтийг тодорхойлж, ялангуяа, өөрийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэл явуулж буй хүмүүс, цалингүй дадлагажигч ажилтан, сайн дурын ажилтан зэргийг агуулга талаас нь тайлбарлаж, тодорхойлолтыг бий болгон хэмжих үзүүлэлтийг тогтоосон;
- **Цалин, ашгийн төлөө ажиллаж байгаа хөдөлмөр эрхлэлтийн** тодорхойлолт,

үзүүлэлтийг сайжруулсан (Ингэснээр бусад төрлийн ажил, тухайлбал, өөрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл явуулж буй хүмүүс, цалингүй дадлагажигч ажилтан, сайн дурын ажилтан зэргийг хөдөлмөр эрхлэлтээс ялгах боломжтой болж байгаа юм).

- **Хөдөлмөрийн насны дээд хязгаарыг** тогтоож өгөхгүй байхыг анхааруулсан.
- Ажиллагчдын **үндсэн ажлын** шалгуур нь хуучнаар хамгийн их цалин хөлс, орлого олдог ажил нь байсан бол шинэ аргачлалын дагуу цалин, орлогоос үл хамааран хамгийн их цаг зарцуулдаг ажлыг үндсэн ажил гэж тодорхойлсон.
- **Ажиллах хүчний дутуу ашиглалтыг** хэмжихдээ уламжлалт ажилгүйдлийн түвшин гэдэг үзүүлэлтээс илүү өргөн хүрээнд авч үзсэн байна.

Үндэсний Статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас мөрдөж байна. Үүнтэй үялдуулан хөдөлмөрийн статистикийн үндсэн үзүүлэлтийн мэдээллийн гол эх үүсвэр болох Ажиллах хүчний судалгааг шинэ ойлголт тодорхойлолт, аргачлалын дагуу явуулж байна.

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна (заалт 15, 65, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм (заалт 11, 16, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас энэ боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ (заалт 16,55, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллагч гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ (заалт 27, ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно (заалт 40, 42 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг дараах үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

1. **Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч** гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль

тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ (заалт 43 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

2. Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм (заалт 47 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

а. хөдөлмөр эрхлээгүй гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг;

б. ажил хийхэд бэлэн гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг;

в. ажил хайж байгаа гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зүүчлэх төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

3. Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм (заалт 40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн;

б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.



2019 оны жилийн эцсийн байдлаар Налайх дүүргийн нийт 37715 хүнээс хөдөлмөрийн насны хүн ам буюу 15-59 насны нийт 22406 иргэн байна. Үүнээс 11232 хүн буюу 50.1 хувь нь хөдөлмөрийн насны эмэгтэй байна.

Хүснэгт 1. Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт 2014-2019 он

Үзүүлэлт	2014		2015		2016		2017		2018		2019	
		эмэгтэй		эмэгтэй		эмэгтэй		эмэгтэй		эмэгтэй		эмэгтэй
Ажиллагчдын тоо	11831	5672	14614	6541	13840	6365	12559	5346	14425	6782	24620	10018
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	11945	5702	16923	8045	15371	7078	13876	6012	15750	7471	26951	11821
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	99.0	99.5	86.3	81.3	90.0	89.9	49.6	43.1	56.3	48.4	48.0	36.9
Ажилгүй иргэдийн тоо	114	30	2309	1504	1531	713	1317	666	1325	689	2331	1803
Ажиллах хүчнээс гадуурах хүн ам	11422	6511	9256	5484	10592	6508	11445	6398	9858	6545	21356	15312
Ажилгүйдлийн түвшин	0.9	0.5	13.6	18.6	10.0	10.1	9.5	11.1	8.4	9.2	8.6	15.3

/ 2019 он Багануур, Багахангай, Налайх дүүрэг/

Хүснэгт 2. Ажиллагчдын тоо, ажилгүй иргэдийн тоо, эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо дүүргээр, хүйсээр 2019 он

Дүүрэг	Ажиллагчид			Ажилгүй иргэн			Ажиллах хүчнээс гадуурах хүн ам		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Хан уул	33971	26737	60708	4562	2673	7235	20759	37272	58031
Багануур, Багахангай, Налайх	14602	10018	24620	528	1803	2331	6044	15312	21356
Баянзүрх	61365	55518	116883	9995	6766	16761	42288	66130	108418
Баянгол	33485	32148	65633	3252	764	4016	26591	41899	68490
Сүхбаатар	24289	21313	45602	3097	2230	5327	13507	30363	43870
Чингэлтэй	26621	25081	51702	4886	1672	6558	15815	29187	45002
Сонгинохайрхан	55769	50081	105850	12453	3788	16241	32213	58738	90951
Улаанбаатар	250102	220898	470998	38773	19696	58469	157217	278901	436118

Ажилгүй иргэн гэдэг нь тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг авч үзнэ.

Ажиллах хүчний судалгааны дүнгээр Нийслэлийн хэмжээнд 58469 хүн ажилгүй гэж бүртгэгдсэнээс Баянзүрх дүүрэг 16761 буюу 28.6 хувь буюу хамгийн өндөр, Багануур, Багахангай, Налайх 2331 буюу 4.0 хувь буюу ажилгүй иргэдийн тоо хамгийн бага байна.

Хүснэгт 3. Эдийн засгийн ачаалал 2014-2019 он

Үзүүлэлт /он	2014	2015	2016	2017	2018	2019
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	11945	16923	15371	13876	15750	26951
Ажиллах хүчнээс гадуурах хүн амын тоо	11422	9256	10592	11445	9858	21356
Эдийн засгийн ачаалал	95.6	54.7	68.9	82.5	62.6	90.5

Хүснэгт 4. Ажиллагчдын тоо насны бүлэг, хүйсээр :

Насны бүлэг	2019		Нийт
	Ажиллагсад		
	Эрэгтэй	Эмэгтэй	
15 - 19	212	-	212
20 - 24	1907	1130	3037
25 - 29	2844	2357	5201
30 - 34	1580	1450	3030
35 - 39	1530	2211	3741
40 - 44	2559	1759	4318
45 - 49	1000	955	1955
50 - 54	1124	156	1280
55 - 59	1520	-	1520
60 - 64	220	-	220
65 - 69	106	-	106
Бүгд	14602	10018	24620

Нийт ажиллагчдын 212 буюу 0.9 хувь 15-19 насны, 3037 буюу 12.3 хувь нь 20-24 насны, 5201 буюу 21.1 хувь нь 25-29 насны, 3030 буюу 12.3 хувь нь 30-34 насны, 3741 буюу 15.2 хувь нь 35-39 насны, 4318 буюу 17.5 хувь нь 40-44 насны, 1955 буюу 7.9 хувь нь 45-49 насны, 1280 буюу 5.2 хувь нь 50-54 насны, 1520 буюу 6.3 хувь нь 55-59 насны, 220 буюу 0.9 хувь нь 60-64 насны, 106 буюу 0.4 хувь нь 65-69 насны иргэд байна.

Хүснэгт 5. Ажиллагчдын тоо эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хүйсээр хүснэгтээр:

№	Эдийн засгийн салбарын ангилал	Хүйс		Нийт
		Эрэгтэй	Эмэгтэй	
1	ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур	169	-	169
2	Уул уурхай, олборлолт	5864	881	6745
3	Боловсруулах үйлдвэрлэл	803	894	1697
4	Цахилгаан, хий, уур агааржуулалт	1123	136	1259
5	Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент	-	65	65
6	Барилга	485	-	485
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	623	852	1475
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2169	1244	3413
9	Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	-	1069	1069
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	220	220	440
14	Удирдлагын болон дэмжлэг, үзүүлэх үйл ажиллагаа	363	-	363
15	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа албан журмын	1923	255	2178
16	Боловсрол	638	2410	3048
17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	-	881	881
18	Урлаг, үзвэр тоглоом наадам	220	972	1192
19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	-	141	141

Зураг 1 . Ажиллагчид эдийн засгийн үйл ажиллагааны салбараар графикаар:



Хүснэгт 6. Ажиллагчдын тоо гэрлэлтийн байдлаар, насны бүлгээр :

Насны бүлэг	Ажиллагсад гэрлэлтийн байдал											
	Огт гэрлээгүй		Гэрлэсэн Батлуулсан		Гэрлэсэн Батлуулаагүй		Тусгаарласан		Цуцалсан		Бэлэвсэн	
	Бүгд	эм	Бүгд	эм	Бүгд	эм	Бүгд	эм	Бүгд	эм	Бүгд	эм
15 - 19	212	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
20 - 24	2674	1130	121	-	242	-	-	-	-	-	-	-
25 - 29	1148	444	3889	1815	163	98	-	-	-	-	-	-
30 - 34	106	106	2670	1311	254	1311	-	-	-	-	-	-
35 - 39	881	881	2769	1239	-	1239	91	91	-	-	-	-
40 - 44	-	-	3954	1396	182	1396	-	-	-	-	182	182
45 - 49	-	-	1319	636	182	636	318	318	-	-	-	-
50 - 54	136	-	1189	65	91	91	-	-	-	-	-	-
55 - 59	-	-	1520	-	-	-	-	-	-	-	-	-
60 - 64	-	-	220	-	-	-	-	-	-	-	-	-
65 - 69	-	-	-	-	-	-	-	-	-	-	106	-
70 +	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Бүгд	5157	2561	17650	6462	1115	4771	409	409	-	-	288	182

Үүнээс нийт эрэгтэй ажиллагчид 14602 байгаагаас хөдөлмөр эрхлэлтийн байдал 2597 буюу 17.8 хувь нь Огт гэрлээгүй , 11188 буюу 76.6 хувь нь гэрлэсэн батлуулсан, 711 буюу 4.9 хувь нь гэрлэсэн батлуулаагүй, 106 буюу 0.7 хувь нь бэлэвсэн иргэн байна.

Үүнээс нийт эмэгтэй ажиллагчид 10018 байгаагаас хөдөлмөр эрхлэлтийн байдал 2561 буюу 25.6 хувь нь Огт гэрлээгүй , 6462 буюу 64.5 хувь нь гэрлэсэн батлуулсан, 404 буюу 4.0 хувь нь гэрлэсэн батлуулаагүй, 409 буюу 4.1 хувь нь тусгаарласан, 182 буюу 1.8 хувь нь бэлэвсэн иргэн байна.

Хүснэгт 7. Ажилгүй иргэдийн тоо насны бүлэг, хүйсээр :

Насны бүлэг	Ажилгүй иргэд		Нийт
	Эрэгтэй	Эмэгтэй	
15 - 19	-	-	-
20 - 24	-	485	485
25 - 29	495	91	586
30 - 34	-	439	439
35 - 39	-	106	106
40 - 44	33	-	33
45 - 49	-	363	363
50 - 54	-	-	-
55 - 59	-	318	319
Бүгд	528	1802	2331

Ажилгүй иргэдийн 2331 буюу 485 буюу 20.8 хувь нь 20-24 насны, 586 буюу 25.2 хувь нь 25-29 насны, 439 буюу 18.8 хувь 30-34 насны, 106 буюу 4.5 хувь нь 35-39 насны, 33 буюу 1.4 хувь нь 40-44 насны, 363 буюу 15.6 хувь нь 45-49 насны, 319 буюу 13.7 хувь нь 55-59 насны иргэд байна.

Хүснэгт 8. Ажиллах хүчнээс гадуурах хүн амын тоо бүлгээр :

Насны бүлэг	Ажилгүйчүүд-2019		2019 оны байдлаар
	Эрэгтэй	Эмэгтэй	
15 - 19	1727	1869	3596
20 - 24	182	2022	2204
25 - 29	359	1092	1451
30 - 34	409	487	896
35 - 39	636	1757	2393
40 - 44	593	439	1032
45 - 49	136	1290	1426
50 - 54	366	1654	2020
55 - 59	91	1381	1472
60 - 64	956	1044	2000
65 - 69	498	402	902
70+	91	1873	1964
Бүгд	6044	15312	21356

Эдийн засгийн идэвхгүй хүн амд эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны нийт хүн ам болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн ам, хөдөлмөрийн наснаас дээш хүн амыг нэрлэнэ.

Тайлбар

Хүснэгт 1. Хүн амын хөдөлмөр эрхлэлт 2014-2019 он

Хүснэгт 2. Ажиллагчдын тоо, ажилгүй иргэдийн тоо, эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо дүүрэг, хүйсээр 2019 он

Хүснэгт 3. Эдийн засгийн ачаалал 2014-2019 он

Хүснэгт 4. Ажиллагчдын тоо насны бүлэг, хүйсээр

Хүснэгт 5. Ажиллагчдын тоо эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хүйсээр хүснэгтээр

Хүснэгт 6. Ажиллагчдын тоо гэрлэлтийн байдлаар, насны бүлгээр

Хүснэгт 7. Ажилгүй иргэдийн тоо насны бүлэг, хүйсээр

Хүснэгт 8. Ажиллах хүчнээс гадуурах хүн амын тоо бүлгээр

Зураг 1 . Ажиллагчид эдийн засгийн үйл ажиллагааны салбараар графикаар

...О...

Хянасан

хэлтсийн дарга

Танилцуулга нэгтгэн, боловсруулсан

Ахлах мэргэжилтэн

Х.Алтанцэцэг

А.Золжаргал

Е-мэйл хаяг: nalaikh@nso.mn

Утас : 7023-3672